



Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна!

“ХЯМРАЛЫН ҮЕИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА”

төслийн танилцуулга



Reliable
information
saves lives





Төслийн үндэслэл, зорилго

КОВИД-19 цар тахлаар дэлхий даяар олон хүн өвдөж, амь насаа алдаад зогсохгүй “эдгэрсэн хүмүүс эрүүл болсон гэсэн үг биш”, “вакцин хийлгэсэн хүмүүс вирус тээж байгаа”, “вакцин нь биологийн туршилт” гэх мэт төөрөгдүүлсэн, зөрчилтэй мэдээлэл вирусын адил хурдан тархах болсон. Цар тахал маш хурдан “инфодемик” буюу **“мэдээллийн цар тахал”** болон хувирч, хүмүүс жинхэнэ вирусын хохирогч болоод зогсохгүй ташаа мэдээллийн улмаас хохирох болов. Үүнд орлогын түвшин доогуур, боловсрол багатай, эсвэл хязгаарлагдсан нөхцөлд байгаа хүмүүс ихээхэн өртөж байна. Тиймээс хямралын үеийн мэдээллийн харилцаа төсөл (Crisis Communication Chapter) нь **мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, баталгаатай мэдээллийг түгээх** бүтцийг бий болгохыг зорьж байна. Үүний тулд:

- Эдгээр бүлгийн мэдээлэл авч буй байдлыг сайжруулах, баталгаатай мэдээллээр хангах
- Хэвлэл мэдээлэл, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага болон олон нийтийн төлөөллүүд нэг дор цугларч өөрсдийн мэдлэг, харилцаа холбоогоо нэгтгэн, мэдээллийг нягтлах, найдвартай, хариуцлагатайгаар түгээх сүлжээ болон ажиллахад оршино.

Уг төслийг **ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбооны яамны** (BMZ) дэмжлэгтэйгээр олон улсад хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг **Дойче Велле Академийн** (DWA) зүгээс **Кени, Замби, Монгол** зэрэг улсуудад хэрэгжүүлж байна. Монгол Улсын тухайд төслийн хэрэгжүүлэгчээр **Хэвлэл мэдээллийн зөвлөл** ажиллаж буй.



Төслийн үйл ажиллагаа, үр дүн

2021.08-09 сар

Төслийн оролцогч талуудыг тодорхойлов



Хямралын мэдээлэл харилцааны туршилтын төсөл хэрэгжүүлэх зорилтот газрыг сонголоо



- Төсөл хэрэгжих газар, төслийн үйл ажиллагааны болон зөвлөх багийн гишүүдийг тодорхойлох уулзалт, ярилцлага, талбарын судалгааг зохион байгуулав.

- Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, нийт хүн ам 16 мянга. Улаанбаатар хотын зүүн захад байрладаг, төвөөс алслагдсан, төвлөрсөн дулаан, цэвэр бохирын системд холбогдоогүй, гэр хороолол дагнасан, хөрсний бохирдол ихтэй, эмзэг бүлгийнхэн болон шилжин суурьшигчид олонтой.



2021.10-12 сар

Төслийн үйл ажиллагааны баг бүрдлээ



- Хэвлэл мэдээллийг төлөөлж mpress.mn ерөнхий редактор О.Ариунбилэг, ММ агентлагийн сэтгүүлч Б.Пүрэв, Эрүүл мэндийн сэтгүүлчдийн холбооны үүсгэн байгуулагч Б.Ундрах,
- Төрийн байгууллагыг төлөөлж ЗГХМОНХГазрын Цахим хэлтсийн дарга О.Баярмаа, ОБЕГ-ын ХМОНХ ажилтан Б.Цэнд, НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны дарга С.Гэрэлмаа,
- Иргэд, иргэний нийгмийг төлөөлж БЗД-ийн 23 дугаар хорооны Нэмүүлэн ӨЭМТ-ийн дарга, их эмч Г.Чанцалмаа, Ид шидийн орон цэцэрлэгийн эрхлэгч М.Мөнхцэцэг, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн менежер Н.Ганчимэг



Б.ПҮРЭВ

МҮОНРТ-ийн редактор,
сэтгүүлч



Б. ЦЭНД

ОБЕГ-ын ХМОНХ
ажилтан, сэтгүүлч



М.МӨНХЦЭЦЭГ

"Ид шидийн орон"
цэцэрлэгийн эрхлэгч



О.БАЯРМАА

Засгийн Газрын
ХМОНХГ-ын ажилтан



Г.ЧАНЦАЛМАА

Баянзүрх дүүргийн
23-р хорооны Нэмүүлэн
ӨЭМТ-ийн их эмч



О.АРИУНБИЛЭГ

Мпрессмн сайтын
ерөнхий редактор



С.ГЭРЭЛМАА

НЭМҮТ-ийн Эрүүл
мэндийг дэмжих,
өвчлөлөөс урьдчилан
сэргийлэх албаны дарга



Б.УНДРАХ

Эрүүл мэндийн
сэтгүүлчдийн клубийн
үүсгэн байгуулагч,
сэтгүүлч



Н.ГАНЧИМЭГ


Хэвлэл мэдээллийн
зөвлөлийн төслийн
менежер

Төслийн багийг чадавхжуулах сургалт зохион байгууллаа



Сургалтыг дотоодын болон олон улсын сургагч багш нарын удирдлага дор **“Хямралын мэдээллийн харилцаа”** сэдвээр 10 долоо хоногийн турш цахимаар зохион байгууллаа. Сургалтын сэдвүүд:

- Хямралын тодорхойлолт
- Хямралын үеийн талуудын үүрэг оролцоо
- Мэдээллийг оновчтойгоор хүргэх аргууд
- Оролцогч талуудаа ойлгох, оновчтой харилцаа холбоо тогтоох
- Мэдээллийг нягтлах
- Мэдээллийг үнэлэх
- Мэдээллийн багц бэлтгэх



Төсөл хэрэгжих зорилтот газартай танилцах аялал зохион байгуулав



БЗД-ийн 23 дугаар хороонд байрлах **Нэмүүлэн ӨЭМТ, Ид шидийн орон хүүхэд хамгааллын төвөөр зочилж**, КОВИД-19 халдварын үед хэрхэн ажиллаж, мэдээ, мэдээллээ түгээж буйтай нь танилцав. Мөн тус хорооны иргэд КОВИД-19 халдвартай холбоотой мэдээллийг хүлээн авч буй байдлыг сонирхон, ярилцлаа.



**Төслийн зорилтот
бүлгийн мэдээлэл
хүлээн авч буй
байдлыг судаллаа**



БЗД-ийн 23 дугаар хорооны иргэдийн коронавируст халдвартай холбоотой мэдээлэл хүлээн авч буй сувгуудыг тодорхойлох, тэдгээрийн хүртээмж, үр нөлөөт байдлыг үнэлэх судалгааг гүйцэтгэв. Мөн


КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдлэгийг үнэлэх ажлыг зохион байгууллаа. Судалгааны дүнд тулгуурлан мэдээлэл харилцааны ажлыг зохион байгуулах юм.



**Гурван улсын
уулзалт #1-т
багаараа оролцов**



Тус төсөл хэрэгжиж буй Кени, Замби улсуудын багтай туршлага солилцох уулзалтад цахимаар оролцож **сургалтаас сурчмэдсэн зүйлс, сорилт, бэрхшээлийн талаар нээлттэй ярилцан, цаашид өөрсдийн мэдлэг, харилцаа холбоогоо нэгтгэн ажиллах төлөвлөгөөг** танилцуулан харилцан санал солилцлоо.



2022.01 сар


Үйл ажиллагааны
төлөвлөгөө, хуваарь
гаргалаа



Гурван улсын
уулзалт #2-т
багаараа оролцов



Мэдээлэл харилцааны
туршилтын төсөл
(мэдээллийн багц
гаргах) эхлэлээ



Багийн гишүүд зорилтот бүлэгт (БЗД 23-р хороо) хандсан **туршилтын мэдээлэл харилцааны ажлаа төлөвлөх, хэрэгжүүлэх уулзалтуудыг** цахимаар болон танхимаар зохион байгуулж ажиллав.




Кени, Замби улсуудын багтай цахимаар холбогдож, мэдээлэл харилцааны туршилтын төслийн төлөвлөгөөгөө танилцуулж, улс тус бүрийн КОВИД-19 халдварын нөхцөл байдлын талаар **харилцан мэдээлэл солилцов.**



КОВИД-19 халдварын **Омикрон хувилбарын шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, вакцины ач тус, үр нөлөөг олон нийтэд ойлгуулах, сар шинийн баяраа гэр гэртээ тэмдэглэхийг уриалах** зорилгын дор тус хорооны иргэд, өрхийн эмнэлэг, мэргэжилтнүүдийг оролцуулсан мэдээллийн багцыг бэлтгэн гаргав. Эдгээр нь:

- БЗД-ийн 23 дугаар хорооны Нэмүүлэн ӨЭМТ-ийн дарга, их эмч Г.Чанцалмаагийн ярилцлага нийтлэгдэв. Тэрээр тус хорооны хэмжээнд КОВИД-19 халдварын өвчлөл ямар байдалтай байгаа талаар болон эрүүл мэндийн төв, эмч ажилтнуудын нөхцөл байдлын талаар өгүүлсэн юм.



- Тус хорооны Нэмүүлэн ӨЭМТ-өөс бэлдсэн сурвалжилга **“Цагийн хүрд” хөтөлбөрөөр** гарав. Омикрон хувилбарын шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, вакцины хүртээмжийн асуудлыг хамарсан.
- Цар тахлын нөхцөл байдлыг сурвалжилсан телевизийн нэвтрүүлэг гарав. КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал БЗД-ийн 23 дугаар хороонд ямар байна вэ? **Өрхийн эмнэлэг хэрхэн ажиллаж байна вэ? Иргэд цар тахалтай хэрхэн тэмцэж байна вэ? Вакцин хийлгэх нь яагаад чухал вэ?** зэрэг өөр өөр өнцөг, туршлага, сургамжийг илэрхийлсэн хүн төвт түүхийг бэлтгэн гаргав.
- **Хэвлэмэл материал бэлдэж түгээв.** Зай барих, маск зүүх, вакцины нэмэлт тунд хамрагдахын ач холбогдол, шалтгааныг тайлбарласан, цагаан сараа гэр гэртээ тэмдэглэхийг уриалсан агуулгатай тус материалуудыг тухайн хорооны хүн ихээр цугладаг, хөл хөдөлгөөн ихтэй газруудаар байрлууллаа.
- Вакцинтай холбоотой эргэлзээт асуултуудад хариулт өгсөн **гарын авлагыг** бэлдэж түгээв. Тус хорооны иргэдийн дунд хийсэн судалгаанд үндэслэж, вакцинд хамрагдахын эсрэг, эргэлзээт бодолд хариу өгөх үүднээс хуурамч мэдээллийн эсрэг **factcheck.mn** сайттай хамтран тус мэдээллийг бэлтгэн гаргасан.





2022.02 сар

Мэдээлэл харилцааны
туршилтын төсөл
(мэдээллийн багц)
үргэлжлэв





- Өрхийн эрүүл мэндийн төвийн фэйсбүүк хуудсыг хөгжүүлэв. Дээрх бүх үйл ажиллагааг сурталчилсан **постер, статистик мэдээ, үйл ажиллагааны тухай мэдээлэл**, иргэдийн асуултад өгөх хариулт зэргээр өргөн хүрээг хамарсан.
- Фэйсбүүк лайв #1-г зохион байгуулав. **“КОВИД-19 халдварын Омикрон хувилбар: Эмчилгээ, үр нөлөө, урьдчилан сэргийлэлт”** сэдвээр төслийн багийн гишүүд мэдээлэл хийж, иргэдийн асуултад хариуллаа.
- КОВИД-19 халдварын Омикрон хувилбарын тухай, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, өвдсөн тохиолдолд авах арга хэмжээ, вакцины нэмэлт тунд хамрагдахыг уриалсан **видео шторкуудыг** бэлдэж түгээв.
- Гэр гэртээ цагаан сар тэмдэглэхийг, вакцины нэмэлт тундаа хамрагдахыг **уриалсан уриалгыг** бэлдэн фэйсбүүкээр түгээв.
- Баярын болон амралтын өдрүүдээр **ӨЭМТ, шинжилгээний цэг, дархлаалжуулалтын цэгийн ажиллах цагийн хуваарь, холбоо барих** мэдээллийг бэлтгэн фэйсбүүкээр түгээв.



- Багийн уулзалтууд болж 1 дүгээр сард явуулсан ажлаа дүгнэн, цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөв. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан мэдээллийн агуулгаа **сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдүүдийн халдвар, хамгаалал чиглэл рүү** хандуулан ажиллахаар тогтов.
- Фэйсбүүк лайв #2-г зохион байгуулав. **“Сургууль, цэцэрлэгийн орчин дахь Ковид-19 вирусын эсрэг халдвар хамгаалал, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа”** сэдвийн хүрээнд БЗД-ийн 23-р хороонд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэгийн баримтлах халдвар хамгааллын дэглэм хийгээд эцэг эхчүүд, хүүхдүүдэд хандсан зөвлөгөөг өгсөн юм.
- Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдүүдийн халдвар, хамгаалал сэдвийн хүрээнд **богино видеонууд** бэлдэн түгээв.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн фэйсбүүк хуудсыг үргэлжлүүлэн хөгжүүлэв. Дээрх бүх үйл ажиллагааг сурталчилсан **постер, статистик мэдээ, үйл ажиллагааны** тухай мэдээлэл, иргэдийн асуултад өгөх хариулт зэргээр ажилласан.
- Төслийн багийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх үүднээс **Crisis Communication Chapter Mongolia** фэйсбүүк хуудсыг ажиллуулж эхлэв.

2022.03 сар

Мэдээлэл харилцааны туршилтын төсөл (мэдээллийн багц) үргэлжлэлээ



- Багийн уулзалтууд болж 3 дугаар сард явуулах ажлаа төлөвлөв. Цар тахлын нөхцөл байдал намжиж буй ч халдвараар өвчилсний дараа урт хугацаанд гарч буй **өөрчлөлтүүдийг даван туулахад** шаардагдах баталгаат мэдээллийг иргэдэд өгөх хэрэгцээнд үндэслэн мэдээлэл бэлдэхээр болов.
- Сургуулийн сурагчдад хандсан үйл ажиллагааг зохион байгуулав. БЗД-ийн 23 дугаар хороонд байрлах нийслэлийн ерөнхий боловсролын 87 дугаар сургуулийн сурагчдад **“КОВИД-19 халдварт өвчний дараах хам шинжийг даван туулах нь”** сэдэвт сургалт, дадлагыг зохион байгууллаа.
- Нийслэлийн ерөнхий боловсролын 87 дугаар сургуулийн сурагчдын дунд **видео, ханын сонин, эссе бичлэгийн** төрөлд “КОВИД-19 халдварт өвчний дараах хам шинжийг даван туулах нь” сэдэвт бүтээлийн уралдаан зохион байгуулав.
- Уралдааны шилдэг бүтээлүүдийг **таниулан сурталчлав**. Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ болон 87-р сургуулийн байр, сүлжээгээр дамжуулан хүүхдүүд, эцэг эхчүүдэд халдвараар өвчилсний дараа урт хугацаанд гарч буй өөрчлөлтүүдийг даван туулахад чиглэсэн мэдээллийг хүргэлээ.
- КОВИД-19 халдварын дараах хам шинжийг даван туулсан туршлагаа хуваалцсан иргэний **нийтлэл** гарав.

2022.03 сар

Мэдээлэл харилцааны туршилтын төсөл (мэдээллийн багц гаргах) үргэлжлэв




БЗД-ийн 23 дугаар хорооны анхан шатны нэгжүүдийн мэдээлэл харилцааны чадавхийг сайжруулах зорилгын дор “Нэмүүлэн” ӨЭМТ, тус хорооны ЗДТГ, Нийслэлийн ерөнхий боловсролын 87-р сургууль, “Ид шидийн орон” хүүхэд хамгааллын төвийн төлөөллийг хамруулсан сургалт зохион байгуулав. Сургалтад үйл ажиллагааны багийн гишүүд оролцож цар тахлын үед ажилласан болон зорилтот хороонд хандсан мэдээллийн багцыг бэлтгэн түгээх явцад **ажилласан туршлагаа хуваалцлаа.**





ВАКЦИНЫ 3,4-Р ТУНДАА ИДЭВХТЭЙ ХАМРАГДАЦГААЯ!

Зай барьж, масkaa зүүж, олон хүнтэй газар очихгүй байя!



Reliable
information
saves lives



Өрхийн эрүүл мэндийн төвийн утас: **88206250**

Зөвлөгөө өгөх нэгдсэн утас: **119**

ХӨСҮТ-ийн зөвлөх утас: **100**



Энэхүү мэдээллийг ХННУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбооны яамны дэмжлэгтэйгээр Дойче Велле Академи, Монголын Хэллэл мэдээллийн зөвлөл хамтран хэрэгжүүлж буй "Баталгаатай мэдээлэл өмнөдөгч" төслийн хүрээнд бэлтгэв. Мэдээллийн агуулга нь захиалагч талын бүс бүтээгчийн байдрыг илэрхийлж буй болно.

Вакцины талаарх түгээмэл эргэлзээ #3

Одоо байгаа вакцины хугацаа дуусаж буй учир хийлгэхгүй.



Бодит баримт

Манай улсад коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад ашиглаж буй Pfizer вакцины заримынх нь шоншго дээрх хүчинтэй хугацаа дуусаж буй. Харин Цельсийн -60-ас -90C хэмийн жон хөлдөөгчид вакциныг хадгалсан тохиолдолд хүчинтэй хугацааг дахин гурван сараар сунган ашиглаж болохыг албан ёсоор мэдэгдсэн захиаг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2021 оны есдүгээр сарын 21-нд Pfizer компанид хүргүүлсэн.

Ингэснээр манай оронд нийлүүлэгдсэн вакцины хадгалалтын хугацаа мөн адил гурван сараар сунгагдаад байна.

Эх сурвалж: Хуурамч мэдээллийн эсрэг factcheck.mn сайт



Reliable
information



german
cooperation

Энэхүү мэдээллийг ХНБ-Уан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн хэлбэрчлэл, хөгжлийн дэмжлэгтэй гэр Дойче Велле Академи, Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран хэрэгжүүлж байр "Баталгаатай мэдээлэл амьдралыг аварч" төслийн хүрээнд бэлтгэв. Мэдээллийн агуулга нь захирагч талын бус бүтээгчийн байр суурийг илэрхийлж байх буюу.



БЗД-ийн 23-р хорооны Нэмүүлэн орхийн
эмнэлгийн дарга, их эмч **Г.Чанцалмаа:**

Хорооны 5 иргэн тутмын 1 нь коронавирусуээр халдварласан. Маш хүнд өвчилсөн хүмүүсийн 60 хувь, хүндээр өвчилсөн хүмүүсийн 24 хувь нь **ВАКЦИНД ХАМРАГДААГҮЙ** байсан.



Reliable
information
saves lives



german
cooperation
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Энэхүү моддлынх нь ХСН-У-ын Зүйн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн хэлбэрнээс яамны дэмжлэгтэйгээр Дойче Велле Академи, Монголын Хувил моддлынх нь зөвлөл хамтран хэрэгжүүлж буй "Талаагаатай моддлын амьдралыг аварч" төслийн зорилд бэлтгэж, моддлынх нь агуулга нь зохиолч талин бүт бүтээгчид байр суурийг өгөхөд хүргэж буй бэлтгэж.





**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН АЖИЛЛАСАН,
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД:**

БЗД-ийн 23 дугаар хорооны ЗДТГ
БЗД-ийн 23 дугаар хорооны "Нэмүүлэн" ӨЭМТ
"Ид шидийн орон" хүүхэд хамгааллын төв
Нийслэлийн ерөнхий боловсролын 87-р сургууль
Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
Онцгой байдлын ерөнхий газар
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Эрүүл мэндийн сэтгүүлчдийн "Цагаан үзэг" холбоо
Монголын үндэсний олон нийтийн телевиз
Mpress.mn сайт
TV9 телевиз



☎ 70000160
✉ info@mediacouncil.mn
🌐 www.mediacouncil.mn
f [mediacouncilmongolia](https://www.facebook.com/mediacouncilmongolia)